



**УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ**

2019 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/105

Улаанбаатар хот

Авто зам дагуух нийтийн эзэмшлийн  
эд хөрөнгийн арчлалт хамгаалалтын чиглэлээр  
авах зарим арга хэмжээний тухай


Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.6, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан "Барилгын ажлын захиалагчийн дүрэм", Засгийн Газрын 2018 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм", Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/926 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтаар батлагдсан "Авто зам, тохижилт ногоон байгууламжийг ашиглах хамгаалах журам", Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар зүйлийн 2.9.5, 3 дугаар зүйлийн 3.1.12 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Авто зам, замын байгууламж дагуух хайс хашлага, гэрэлтүүлгийн шон, гэрлэн дохионы шон, ногоон байгууламж болон бусад нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг эвдэж гэмтээсэн, авто зам бохирдуулснаас үүссэн хохирлыг тогтоолгох асуудлыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж, нөхөн төлбөрийг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Төрийн сан банкны нэмэлт дансанд төвлөрүүлж ажиллахыг Инженерийн байгууламжийн хэлтэс /Т.Хэрлэн/-т үүрэг болгосугай.

2.Нөхөн төлбөрийн зориулалтаар хуримтлагдсан төсвөөс тушаалын 1 дүгээр заалт дахь нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг шинэчлэх, сэргээн засварлах, шилжүүлэн байршуулах ажлыг зам, замын байгууламж барих, гэрэлтүүлэг болон тохижилт, ногоон байгууламжийн ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөлтэй байгууллага, аж ахуй нэгжээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулж, ажлын явцад хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг Аудит дотоод хяналтын хэлтэс /Ц.Рэгзэдмаад/-т даалгасугай.

3.Нөхөн сэргээлтийн ажлыг ашиглалтад хүлээн авах үүрэг бүхий Ажлын хэсгийг хавсралт ёсоор байгуулсугай.

4.Нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэлээр холбогдох дүрэм, журмын дагуу ашиглалтад хүлээн авч, ашиглалт хариуцсан байгууллагад хүлээлгэн өгч ажиллахыг Ажлын хэсэг /Ц.Рэгзэдмаад/-д авто зам, замын байгууламж дагуух хайс хашлага, гэрэлтүүлгийн шон, гэрлэн дохионы шон, ногоон байгууламж болон бусад нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн эвдэрч гэмтээсэн, авто зам бохирдуулснаас учруулсан хохиролыг хэвийн байдалд оруулсан ажлыг 2019 онд албаны нэмэлт дансанд нөхөн төлбөрийн зориулалтаар төвлөрүүлсэн хөрөнгөөс гүйцэтгэлээр санхүүжүүлж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.


УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



D:\backup\_old\_pc\Work documents\doc 2019\Тушаал doc.docx

1110300335

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн  
2015 оны 09 сарын 17  
өдрийн 11:05 тушаалын хавсралт



## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч	Ц.Рэгзэдмаа Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Аудит, дотоод хяналтын хэлтсийн дарга
Гишүүд	Р.Даваасүрэн Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн ахлах мэргэжилтэн  Б.Цэрэнсодном Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын Засвар ашиглалт, хяналтын хэлтсийн дарга  Н.Цогтоо Цагдаагийн Ерөнхий газрын Тээврийн цагдаагийн албаны Техник замын хяналтын хэлтсийн мэргэжилтэн цагдаагийн хошууч  Д.Сүхбат Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн Ногоон байгууламжийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн  Э.Сүлд-Эрдэнэ Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн авто зам хариуцсан мэргэжилтэн  Ш.Чанцалнурмаа Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн Хот чимэглэл, нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга	П.Чойжилжав Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Аудит дотоод хяналтын хэлтсийн мэргэжилтэн